ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2019 ОН)

ХОВД ХОТ 2020 ОН

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙНХЯНАЛТ, АУДИТЫНАЛБАНЫ
2019 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2019.12.31 Ховд

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР.

Санхүүгийн хяналт аудитын алба нь Монгол улсын Засгийн газрын 2014 оны 327-р тогтоол, Аймгийн Засаг даргын 2014 оны 11-р сарын 10-ны өдрийн А/577 тоот захирамжаар байгуулагдаж, 2019 онд албаны дарга-1, ахлах байцаагч-2, байцаагч-2, дотоод аудитор-1 дотоод ажилтан-1 нийт 7 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн хяналт аудитын албаны зорилго нь Монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны зарчим: Албаны үйл ажиллагаа нь ил тод, биеэ даасан, хараат бус байж, хяналт шалгалтын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтлана.

Үйл ажиллагааны чиглэл: Орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийнэ.

Дээрх зорилгоос 2019 онд дараахь зорилтыг дэвшүүлэн ажиллалаа.

1. Хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлж, санхүүгийн ажилтнуудын сахилга батыг сайжруулах.
2. Албаны дотоод үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, боловсон хүчний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх.

Ховд аймгийн Санхүүгийн хяналт,аудитын албаны даргаар Б.Нармандах, ГӨөдэй нар, санхүүгийн улсын ахлах байцаагчаар Ж.Цэнд-Аюуш, Ц.Цэцэнхараацай нар, Санхүүгийн хяналтын улсын байцаагчаар Ц.Бадрал, Д.Болормаа нар, дотоод аудитораар П.Мягмартүвшин, дотоод ажилтнаар Н.Балт, нийт 7 хүний орон бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Үр дүнд хүрсэн ажил:

2019 онд албаны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэгдүгээр зорилтын хүрээнд 8, хоёрдугаар зорилтын хүрээнд 11, хүний нөөц сургалтын чиглэлээр 4, сурталчилгаа, олон нийттэй харилцах чиглэлээр 2, санхүү, аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр 2, бүгд 27 ажил төлөвлөж, төлөвлөгөөний биелэлтийг 96.1хувь биелүүлж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд албаны хурлыг 10 удаа хийж, хяналт шалгалтаар илэрч буй зөрчил дутагдлыг арилгах, графикт шалгалтыг төлөвлөсөн цаг хугацаанд нь явуулж байгууллагын менежертэй байгуулсан төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг ханган биелүүлэх, цаг үеийн асуудлыг тухай бүр авч хэлэлцсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулсаны дагуу 2019оныүйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт шалгалтын графикаар 9 сумын 63 төсөвт байгууллага болон аймгийн төвийн12 төсөвт байгууллага, 2 төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар бүгд77 байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөж,Булган сум, Чандмань сумын нийт төсөвт 14 байгууллагыг Төрийн аудитын газраас гүйцэтгэлийн хяналт шалгалт хийгдсэнтэй холбоотой шилжүүлсэнээр, 60 төсөвт байгууллага болон төрийн өмчийн байгууллагад хяналт шалгалтыг хийж, төлөвлөгөөний биелэлт 96.1 хувиар биелсэн.Жаргалант сумын 12 жилийн сургууль1, Хүүхдийн Цэцэрлэг 2, нийт 3 байгууллагад санхүүгийн хяналт, шалгалт хийгдэж байна.

Монгол улсын Сангийн яамны удирдамжийн дагуу тусгай захилгат 4байгууллагабуюу Нийгмийн халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудит, Гадаадын иргэн харъяатын газрыг тус тус төлөвлөснөөс Нийгмийн халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудит, Гадаадын иргэн харъяат зэрэг 4 газар төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 100 хувь хийж, шалгалтын дүн мэдээг аймгийн дотоод аудитын хороогоор хэлэлцүүлж, Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлж ажилласан.

Засаг даргаар ахлуулсан Дотоод аудитын хороог 2018 оны 11 сарын 06-ны өдрийн А/684 тоот захирамжаар 7-н хүний бүрэлдхүүнтэй байгуулж,2019 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, тухайн жилд шалгагдсан байгууллага бүрийн шалгалтын дүн мэдээг 5удаагийн хурлаар хэлэлцэн батлуулж, хорооны хурлын тэмдэглэл 5, 12 тогтоол шийдвэр гаргаж биелэлтийг тооцон ажиллаж байна.

ХОЁР. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖЫН ХЭРЭГЖИЛТ ШАЛГАЛТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН ТАЛААР.

Санхүүгийн хяналт шалгалтаар нийтдээ 60 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж,428.8 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж,улсын байцаагчийн 16 албан шаардлагаар 249.1 сая төгрөгийн зөрчлийгарилгуулахаар, 202 актаар179.7 сая төгрөгийг барагдуулахаар тогтоон орон нутгийн төсөвт101.8сая төгрөгийг тухайн байгууллагад77.9 сая төгрөгийг тус тусоруулахаар шийдвэрлэж ажилласан байна.

Тайлант хугацаанд 6 өргөдөл, 102 албан бичиг ирсэнийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлж ажилласан ба 91 бичгийг дээд шатны байгууллага, харилцагч иргэн байгууллагад явуулсан байна.

Тайлант хугацааны актын төлбөрийг 79 % биелүүлж, орон нутгийн төсвийн орлогын 100160051411 тоот дансанд 101.1сая төгрөгийг барагдуулсан байна.

Өмнөх актын төлбөрийн үлдэгдэл 2018оны жилийн эцсийн байдлаар 407.7 сая төгрөг байсан бол 2019 оны байдлаар 289.7 сая төгрөг болж барагдалт 29,0 хувьтай байна.

Өмнөх оны актын төлбөрийн үлдэгдлээс 36 сая төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацаанд 428.8 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэнийг зөрчлийн төрлөөр ангилан үзвэл:

1. Албан татвар төлбөр хураамж 1.7 хувь буюу 7.6 сая төгрөг
2. Төсвийн хөрөнгийг бусдад зээлдүүлж, түр ашиглуулсан 4.2 хувь буюу 18.4 сая төгрөг
3. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 31.7 хувь буюу 136.1 сая төгрөг
4. Үндсэн баримтгүй зарцуулсан, данс бүртгэлд тусгаагүй 36.6 хувь буюу 157.0 сая төгрөг
5. Дутуу болон илүү олгогдсон цалин хөлс, нөхөн олговор 0.8 хувь буюу 37.1 сая төгрөг
6. Ашиглаж дутагдуулсан хөрөнгө 0.8 хувь буюу 3.6 сая төгрөг байна.

7. Бусад төлбөр 17.6 хувь буюу 75.6 сая төгрөг

Үүнээс харахад нийт төлбөрийн дийлэнхийг үндсэн баримтгүй зарцуулсан,данс бүртгэлд тусгаагүй, өр авлага үндэслэлгүй хаасан, дутуу болон илүү олгогдсон цалин хөлс, нөхөн олговор, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчил 17.6-36.6хувийг эзэлж байна.

Сангийн яамны удирдамжаар 2019 оны 04 сард Нийгмийн даатгалын хэлтсийн сангууд, Халамжийн сангийн үйл ажиллагаа, шилэн дансны гүйцэтгэлийн аудит, 10 сард Гадаадын иргэн харьяатын газрын санхүүгийн баримтанд тус тус хяналт шалгалт хийж дараах зөрчил дутагдал илрүүлж, зөрчлийг арилгууллаа.

1. Нийгмийн даатгалын сангуудын үйл ажиллагаа

2018 онд НДШ, СДД, ЭМД гэсэн төрөл бүрт орлогын төлөвлөгөөг 104.5-116.4%-аар биелүүлж, нийт дүнгээрээ 1,008.7 сая төгрөг буюу 5.4%-аар давуулан биелүүлсэн.

Тус хэлтсийн сангуудад НДЕГ, МХГ, СХАА-аас хийсэн шалгалтаар нилээд хэмжээний төлбөр зөрчлүүд илэрсэн байхад түүнийг бүрэн барагдуулаагүй, холбогдох ажил хариуцсан ажилтнуудад хариуцлагын арга хэмжээ аваагүй байна.

Дээрхи байгууллагуудаас хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлүүд дахин давтагдан гарсан байна.

2018 оны сангуудын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар 114 хүнтэй холбоотой 41,690.8 мянган төгрөгийн зөрчил төлбөр илэрч, 35,687.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, илүү олгосон тэтгэмжийн 3,907.7 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн дансанд төлүүлэхээр, дутуу олгосон тэтгэмж 2,095.9 мянган төгрөгийг Сангийн данснаас нэг удаа нөхөн олгуулахаар тус тус шийдвэрлэн ажилласан.

2. Халамжийн сангийн үйл ажиллагаа.

Халамжийн эх сангийн үйл ажиллагааны санхүүгийн баримтын бүрдэл хэвийн хэмжээнд явагдаж тайланг хуулийн хугацаанд зөрчилгүй санал дүгнэлттэй тушааж хэвшсэн боловч ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлж, санхүүжилт авсан,хүнсний эрхийн бичгийн хувийн хэрэг, дэлгүүрийн тайлан, ахмадын хүндэтгэлийн үйл ажиллагааны анхан шатны баримтууд нь зөрчилтэй бүрдэл болоогүй баримтаар гүйлгээ хийгдэж, сангаас үйл ажиллагааны зардал төлсөн зөрчил илэрсэн.

Шилэн дансны нэгдсэн системд 2018 оны байдлаар 20 нэр төрлийн 149 мэдээллийг байршуулахаас 105 мэдээллийг хугацаанд нь, 42 мэдээллийг хугацаа хоцроож, 2 нэр төрлийн 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Өмнөх шалгалтаар илэрч байсан зөрчил дутагдал дахин давтагдсан. Шалгалтаархаламжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд 75,494,525 төгрөгийн зөрчил

илэрсэний 2,459,100 төгрөгийг улсын байцаагчийн актаар төлүүлэхээр 73,035,425 төгрөгийг хугацаатай үүрэг өгч албан шаардлагаар арилгахаар шийдвэрлэн зөрчлийг арилган ажиллалаа.

3. Төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн нийтлэгзөрчил.

Сургуулийн захирлууд болон Цэцэрлэгийн эрхлэгч нарт 2016-2017 онд мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон, багш болон төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох хэмжээнээс илүү тооцон олгосон, амралт, цалин давхардуулан олгосон, мэргэжлийн зэрэггүй багшид зэрэг тооцон олгосон, аймгийн Засаг даргын захирамж болон сургуулийн захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд 2017 оны 12 дугаар сард Монгол улсын Засгийн газраас төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн урамшуулалыг олгосон, үр дүнгийн урамшуулалыг тушаал шийдвэрээс дутуу олгосон,захирлын тушаалаар замын зардал, ажлын хөлс, ахмадуудад хүндэтгэл үзүүлэх зэрэг хөрөнгө зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл хангаагүй байхад гүйлгээ хийсэн, албан томилолтонд бичилт хийгдээгүй байхад томилолтын зардал олгосон, автомашинд хөдөлгүүр, аккумлятор, бусад сэлбэг хэрэгсэл олгохдоо норм тооцож, тооцоо бодоогүй, комиссын дүгнэлт гаргаагүй, дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг мөрдөөгүй дутуу олгосон,сургуулийн хөрөнгүүдийг хэсэгчилсэн тооллого хийхэд багш нарын зөөврийн компьютерийг хулгайд алдсан, дутагдуулж хохирол учруулдаг зэрэгзөрчлүүд тус тус илэрч байна.

Шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн томилогдсон багш, захирал нарт ажилгүй байсан хугацааны цалин хөлс эргүүлэн олгож, төлөвлөгдөөгүй зардлыг олгож, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Дээрх асуудлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх шаардлагатай.

2016-2018 оны зарим өдрийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны цэсийг зөрчиж, цэсэнд байхгүй хоол хүнсний материал болох чихэр, тараг, хатаасан жимс, ааруул, зөгийн бал зэрэг хүнсний материалыг хүүхдийн талондзарлага болгосон, 2017 оны 12 сард цэцэрлэгийн эрхлэгч нарын үр дүнгийн урамшуулалолгохдоо сумын Засаг даргын ажил дүгнэсэн үзүүлэлт захирамж шийдвэргүй, аймгийн Засаг даргын захирамжгүй эрхлэгч нарт олгосон, Цэцэрлэгийн нэр бүхий багш нартD үнэлгээтэй дүгнэгдсэн байхад үр дүнгийн урамшуулал олгосон, цалингийн авлагыг тооцон баталгаажуулаагүй цалингийн сангийн хэмнэлтийг илүү шилжүүлсэн, ажилтнууд чөлөөтэй хугацаанд нэмэгдэл хөлс олгосон, мөн өвчтэй хугацаанд цалин хөлс олгосон, Бүх сумдад Төрийн сангийн мэргэжилтэний үндсэн чиг үүрэгт хамаарах ажилд ажил хавсарсаны нэмэгдэлд үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдлийг илүү тооцон олгосонзэрэг зөрчлүүд илэрсэн.

Шатахууны тооцоог алдаатай бодсон, жолоочийн тооцоог үнэн зөв бодож баталгаажуулаагүй, няравын тайланг стандартын дагуу гаргаагүй, Санхүүгийн тайлангаас бараа материалын тайлан зөрүүтэй, Ховд аймгийн төв болон Улаанбаатар хотод томилолтоор ажилласан томилолтын хуудасны хоног засвартай, гарын үсэг хуурамч зурдаг, томилолтын дуудсан бичиг, тайлан , томилолтын хуудасгүй байхад томилолт олгосон, багийн засаг дарга нарын албанд өгсөн мотоциклыг хөрөнгөнд бүртгэж аваагүй зэрэг зөрлүүд илэрч байна.

Суманд байхгүй үйл ажиллагаа явуулахгүй зээлдэгчид зээл олгодог, зээлдэгч үйл ажиллагаа явуулаагүй улиралын чанартай, зээлдэгчийн 2011-2018 онуудад авсан зээл хугацаа хэтэрсэн байгаад гэрээний дагуу алданги ногдуулан тооцоогүй, төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахдаа сумын иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах ажлыг зөрчсөн,Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулахад зориулж шалгагдсан сумууд мөнгө баталж зарцуулсан, Иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй, орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал болон хөрөнгийн зардалд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг батлан зарцуулсан, цайллага дайллага, хүлээн авалтанд ихээхэн хэмжээний зардал зарцуулсан, Засаг даргын захирамжаар Гамшгаас хамгаалах ажлын төлөвлөгөө ирсэн бичигт үндэслэн өвс тэжээл авсан боловч уг тэжээлийг үнэ тогтоон малчдад зохих ханшаар олгоогүй багийн дарга нар малчин айл өрхөд үнэгүй тарааж буцаан тооцоо хийгээгүй, зарим ажил хүлээн авсан комиссын актгүй, ажлыг хэдий хугацаанд хийх талаар хугацааг гэрээнд тусгаж дүгнээгүй, хийгдэж байгаа ажлын үе шатны дараалалгүй зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

4. Гадаадын иргэн харьяатын газар.

Шалгалтаар 51 хүнтэй холбоотой 4,823,475 төгрөгийн зөрчил илрүүлж, 3,102,189 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод оруулахаар, 208,886 төгрөгийн цалин хөлс буцаан олгуулахаар акт тогтоон, 1,512,400 төгрөгийн хөрөнгө данс бүртгэлд тусгуулахаар тус тус улсын ахлах байцаагчийн акт бичиж, зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж, албан шаардлага өгч ажилласан байна.

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хөрөнгө орлогод аваагүй, Засгийн газраас тогтоосон цалингийн шатлал мөрдөөгүй, үр дүнгийн урамшуулалт цалин, нэмэгдэл цалинг илүү олгосон, унаа хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон, шатахууны зардлыг няраваар дамжуулан зарцуулаагүй зөрчлүүд байгааг арилган, холбогдох хууль, журмын хэрэгжилтэнд анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн зөвлөмж өгч ажилласан байна.

5. Шим-Ус ОНӨААТҮГ

Санхүүгийн хяналт тавих эрх бүхий албан тушаалтан кассаар их хэмжээний бэлэн мөнгө гаргаж, бараа материал нийлүүлсэн. Анхан шатны баримтанд хүлээн авсан, өгсөн

хүний гарын үсэг зуруулдаггүй, кассаар ихээхэн хэмжээний мөнгө гаргаж, бүртгэлээр тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн.

Өр барагдуулах, орлого нэмэгдүүлэх тал дээр хийсэн ажил хангалтгүй, төсвийн хүндрэлтэй байхад үргүй зардал гаргаж, шинэ жил тэмдэглэх болон шатахууны зардалд Монгол Улсын Их хурлын 47-р тогтоол зөрчиж ихээхэн зардал гарсан.Шүүхийн шийдвэрээр удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд 28,100.0 мянган төгрөгийн цалин олгосон, 2өмгөөлөгчийн хөлсөнд 4,400.0 мянган төгрөгийн хөлс төлсөн зэрэг зөрчлүүд байна.

2016-2017 онуудад тухайн байгууллага төсөв, орон тоо батлуулаагүй үйл ажиллагаа явуулсан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй зөвхөн 10 сар, 12 сард 23-26 төрлийн мэдээллийг хугацаандаа оруулсан бусад саруудад хугацаа хоцруулан мэдээлсэн байсныг улсын байцаагчийн акт тогтоон албан шаардлагаар хэрэгжилтийг хангуулан ажилласан.

6. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалт

Аймгийн 2019 оны 1,2,3,4 дүгээр улирлын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг Сангийн яам болон аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын Санхүү Төрийн сангийн хэлтэст хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй холбогдох албан тушаалтнуудад арга хэмжээ авах талаар зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар нэр бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцон ажилласан байна.

Шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар шалгалт хийх явцадхуулийн зөвлөгөө өгөх, гарын авлага, сурталчилгааны материалаар хангах, зөрчлийн улмаас гарах үр дагаварын талаар мэдээлэл хийж хэвшсэн.

Манай аймагт үйл ажиллагаа явуулж буй 188 төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг үзүүлэлт тус бүрээр сар бүрийн 9-ний өдөр тогтмол хянан шалгаж, улирал бүр Сангийн яам, аймгийн Засаг даргад тайлагнасан байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 12 дүгээр сарын 25-ны байдлаар авч үзвэл Ховд аймагт тус хуулийн хэрэгжилт 90.0 хувийн биелэлттэй байна.

ГУРАВ. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.

Улаанбаатар хотод Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас 2019 оны 06 дугаар сард зохион байгуулсан албаны дарга нарын сургалт, УИХ-ын төсвийн байнгын хорооноос зохион байгуулсан “Төсвийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, гарч буй үр дагавар, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт хэлэлцүүлэгт албаны дарга Г.Өөдэй,Улсын салбарын дотоод аудиторуудын нэгдсэн зөвлөгөөнд 2019

оны 11 дүгээр сард5 өдрийн сургалт, спортын арга хэмжээнд албаны дарга, 4 байцаагч, 1 дотоодажилтан нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцлоо. Спортын арга хэмжээний теннисний тэмцээнд 5 дугаар байр, гар бөмбөгийн тэмцээнд 2 дугаар байрыг тус тус эзэлсэн.

Нээлттэй хаалганы өдөр, иргэдийн өдрийг зохион байгуулахаар гаргасан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж тайлан мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж орон нутгийн телевиз, Ховдын мэдээ сонин, www.sankhuu.kho.gov.mnмэдээллийн сайтаараа дамжуулан байгууллагын үйл ажиллагаа, шалгалтын дүн мэдээгээ нээлттэй мэдээллэж, сурталчилж байна.

“Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулах ажлын хүрээнд:

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Ховд аймаг дахь салбартай хамтран Улаанбаатар хотын мэргэжсэн нягтлан бодогчдын институдын захирал Д.Нацагдоржоорахлуулсан баг болон баруун 5-н аймгийн санхүүгийн ажилтнуудыг оролцуулсан уулзалт сургалт, өдөрлөгийг2019 оны 10 дугаар сарын 10-12-ны өдөрзохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг угтаж бэлтэл ажлыг ханган, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд, аж ахуй нэгж байгууллагуудад урилга, хөтөлбөр тараан ажилласан.Уг өдөрлөгт Баруун 5 аймгийн төсвийн болон аж ахуй нэгж байгууллагуудын 250 гаруй санхүүчид оролцлоо. Санхүүгийн хяналт аудитын алба нь МНБ-ын институтэд болон тухайн аймгуудаас ирсэн хүмүүсийг Манхан сумын “Гурван цэнхэрийн агуй” байгалын үзэсгэлэнт газрыг танилцуулан тухайн

суманд санхүүгийн үйл ажиллагаанд анхаарах асуудлаар зөвлөгөө өгч нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж ажилласан.

Нээлттэй хаалганы өдөрлөгөөр төсвийн тухай хууль тогтоомж, хяналт шалгалтаар илэрч байгаа зөрчил дутагдлын талаар ярилцлага хэлэлцүүлэг амжилттай явагдсан.

Уг өдөрлөг, уулзалт нь санхүүгийн ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, төрөөсбаримталж буй нягтлан бодох бүртгэлийн бодлого, аймаг, орон нутгийн дэвшүүлж байгаа зорилго, зорилтыг сурталчилсан ажил болсон.

Мянгад суманд 2019 оны 4 дүгээр сард болсон 200 гаруй төрийн албан хаагчийн

өдөрлөг уулзалтанд Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч Ж.Цэнд-Аюуш санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагааны чиглэлийн тухай ба Цалин хөлсний нэмэгдэл хэрхэн олгох талаар 1 цагийн сургалтыг зохион байгуулсан.

“**Иргэдийн өдөр**” зохион байгуулах ажлын хүрээнд:

Байгууллагынхаа**www.sankhuu.kho.gov.mn** цахимхуудсанд 2019 онд хийсэн хяналт шалгалтын болон бусад мэдээ мэдээллийг байршуулж, ажиллаж байна. Тус сайтаар 2019 оны байдлаар аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу хяналт шалгалтанд хамрагдсан 60төсөвт байгууллагын хяналт шалгалтын талаар мэдээллийг нээлттэй байршуулсан.

Санхүүчдийн 108 дэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний спортын тэмцээн уралдаанд амжилттай оролцон гар бөмбөгийн тэмцээнд 2 дугаар байр, хөгжөөнт буухиа тэмцээнд 3 дугаар байрыг тус тус эзэлсэн.

Байгууллагынхаа 2019 оны ажлыг дүгнэж, ажилтан албан хаагчдын хөдөлмөрийг үнэлүүлж, санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч Ж.Цэнд-Аюуш Санхүү, банкны тэргүүний ажилтан, Нийгмийн хамгааллын тэргүүний ажилтан цол тэмдгээр, санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч Д.Болормаа Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан, аймгийн Засаг даргын Жуух бичгээр,санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч Ц.Бадрал Санхүү, банкны тэргүүний ажилтан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны жуух бичгээр, Дотоод аудитор П.Мягмартүвшин аймгийн Засаг даргын Жуух бичгээр тус тус шагнагдсан.

Байгууллагын 2019 оны аварга ажилтнаар санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч Ц.Бадрал шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.

ДӨРӨВ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.

Байгууллагын урсгал санхүүжилтанд 128,6 сая төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр 128,6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Д/Д	Төсвийн байгууллага/ эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Хэмнэлт/ хэтрэлт
		Жилээр	Тайлант үе /өссөн дүнгээр/	Дүн	
1	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	128631700	128631700	128580402	51298.05
2	УРСГАЛ ЗАРДАЛ	128031700	128031700	128580402	51298.05
3	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	128031700	128031700	125980402	51298.05
4	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	83455000	83455000	83435196	19804
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10431900	10431900	10410115.15	21784.85
6	Хангамж, бараа материалын зардал	7364988	7364988	7364978.8	9.2
7	Эд хогшил, урсгал засварын зардал	3559500	3559500	3549800	9.7
8	Томилолт, зочны зардал	10932600	10932600	10932600	0
9	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	9537712	9537712	9537712	0

	үйлчилгээний төлбөр, хураамж				
10	Бараа үйлчилгээний бусад зардал	750000	750000	750000	0
11	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	2600000	2600000	2600000	0
12	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	128631700	128631700	128580402	51298.05
13	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128631700	128631700	128580402	51298.05

Төсөвт тусгагдсан эд хогшлын зардлаас албаны хэрэгцээнд зөөврийн компьютер 2 ширхэгийг бэлтгэж, албаны материаллаг баазыг бэхжүүллээ.

Байгууллагын 416, 418, 420 тоот өрөөнүүдийн урсгал засварыг хийж, хаалга, цонхыг сольж, 1791,0 мянган төгрөгийг зарцуулж, ажиллах орчин нөхцлийг сайжруулж ажилласан.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хуулийн хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж, байгууллагынхаа мэдээллийн самбарт байршуулж байна. 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар “ИТГЭМЖЛЭЛ” авч, аймгийн төсөв, санхүүгийн ажилтнуудын ажлыг дүгнэсэн үзүүлэлтээр 2 дугаар байранд шалгарсан.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын шилэн дансны 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээллийн самбараар болон шилэн дансны **www.shilendans.gov.mn**сайтад бүрэн байршуулж ажиллалаа.

ТАВ. ДҮГНЭЛТ

Үйл ажиллагааны талаар: Ховд аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн хяналт, дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гарган эрсдэлийн удирдлагаар ханган ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгууллагын үндсэн үйл ажиллагааг хангах зорилгоор нийт 27 арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан гэрээ байгуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг тухайн тайлант жилд 96.1хувьтай биелүүлж ажилласан.

Албан хаагчид төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн дүрэм, дотоод аудиторын ёс зүйн дүрмийг чанд мөрдөн сахилгын зөрчилгүй ажилласан.

Байгууллагын ажилчдыг сургалт семинарт хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх тал дээр үр дүнтэй ажлуудыг хийсэн.

Санхүүгийн хяналт шалгалтаар:Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж, техник хэрэгслээр бүртгэлийн ажлыг зохион байгуулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд төрийн сан урьдчилсан хяналт тавьж ажилладаг болсноор төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сайжирсан. Гэвч урьд өмнө ньгарч байсан зөрчил давтагдах,төлбөр зөрчлийг

цаг хугацаанд нь барагдуулах талаар төсвийн менежер, санхүүгийн ажилтан нар хангалтгүй ажиллаж байгаагийн дээр хамрах хугацаа урт, төсөв санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой гарах зөрчлийн хэмжээ тодийлэн сайн буурахгүй байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талааранмгийн Засаг даргаар ахлуулсан дотоод аудитын хороонд танилцуулж, цаашид хяналт шалгалтын зөрчлийг бууруулах талаар холбогдох арга хэмжээ, шийдвэрүүдийг гаргуулж ажилласан. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтранактын төлбөрийн үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

ЗУРГАА. САНАЛ

Монгол улсын Сангийн яаманд:

1. Төсвийн тухай хууль,Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хуулинд санхүүгийн хяналт, шалгалтын байцаагч нарын эрх үүрэг, хариуцлагын тогтолцоог тусгаж өгөх, дотоод аудитын тухай хуулийг батлуулах, ноцтой зөрчил гаргасан тохиолдолд торгуулийн арга хэмжээ авч байх нөхцлийг бүрдүүлэх.

2. Дотоод аудиторуудын мэргэшил, мэдлэг, чадвараа тасралтгүйдээшлүүлэн хөгжүүлэх боломжийг ханган мэргэшүүлэх сургалтыг улсын салбарын дотоод аудиторын тодорхой сэдэвчилсэн сургалтыг үе шаттай зохион байгуулж, гадаадын болон салбарын ижил төстэй байгууллагуудтай туршлага судлуулах арга хэмжээ төлөвлөгөөтэй зохион байгуулах.

3. Аймагт ажиллаж байгаа улсын байцаагчийн цалинг Засгийн газрын агентлагийн улсын байцаагчийн цалингийн сүлжээ, шатлалтай дүйцүүлж цалинжуулах асуудлыг Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлэх.

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА Г.ӨӨДЭЙ

ТАЙЛАН БИЧСЭН :

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Ж.ЦЭНД-АЮУШ